



БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан)¹

ЗӨВХӨН СЭЖИГТЭЙ ГЭХ ҮНДЭСЛЭЛЭЭР ХҮНИЙ БИЕИЙГ НҮЦГЭЛЖ ҮЗЛЭГ ХИЙЖ БОЛОХГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: Ra 2023/01/0304-14, Landespolizeidirektion Wien (хариуцагч: Вена хотын Цагдаагийн газар) v V.B., Mag. Clemens Lahner (гомдол гаргагч: иргэн V.B. болон түүний өмгөөлөгч Mag. Клеменс Ланер)

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 9 дүгээр сарын 19 өдөр

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

2023 оны 02 дугаар сарын 20-ний өдөр иргэн V.B нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хөдөлгөөн болох (Klimakleber)-д оролцсон бөгөөд Вена хотын Цагдаагийн газраас жагсаалыг тараах явцад иргэн V.B-г Захиргааны зөрчлийн тухай хуулийн² 35 дугаар зүйлийн 3-т заасан үндэслэлээр баривчилжээ.

Иргэн V.B-г баривчилсны дараа Вена хотын цагдаагийн байранд цагдаа нар түүний биед “супер цавуу” байж магадгүй гэх үндэслэлээр нүцгэлж биед нь үзлэг хийжээ. Учир нь (Klimakleber) гэх хөдөлгөөнд оролцож буй жагсагчид нь машин зам дээр өөрсдийн биеийг супер цавуугаар наах байдлаар эсэргүүцлээ илэрхийлдэг байна. Гэвч биеийг нүцгэлж үзлэг хийх явцад ямар нэгэн аюултай зүйл олдоогүй байна.

Иргэн V.B-гийн зүгээс Вена хотын Цагдаагийн газар Цагдаагийн аюулгүй байдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1-д³ заасныг зөрчин үндэслэлгүйгээр нүцгэлж биед үзлэг хийсэн гэж үзэн шүүхэд гомдол гаргажээ. Харин Вена хотын Цагдаагийн газар тус хуульд заасны дагуу биед үзлэг хийхэд “аюултай нөхцөл байдлыг тогтоох ямар нэгэн үнэлгээ” шаардагдахгүй гэж маргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Анхан шатны шүүхээс: Хариуцагч Вена хотын Цагдаагийн газар аюултай нөхцөл байдал байгаа эсэхийг бүрэн үнэлж, тогтоолгүйгээр гомдол гаргагчийн биеийг нүцгэлэн үзлэг хийж хувь хүний нэр төр, хувийн нууцад халдсан гэж үзэн Холбооны засгийн газарт гомдол гаргагч иргэн V.B-ийн хохирлыг нөхөн төлөхийг даалгасан.

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: https://www.vwgh.gv.at/rechtsprechung/aktuelle_entscheidungen/ra_2023010304.html, Шүүхийн шийдвэрийг хураангуйлахдаа эх хувилбарын бүтцийг өөрчилсөн болно.

² Verwaltungsstrafgesetz (1991), Захиргааны зөрчлийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “хууль бус үйлдлээ зогсоохыг анхааруулсан эсхүл анхааруулга өгсөөр байхад үйлдлээ зогсоогоогүй”

³ Sicherheitspolizeigesetz (1991), Цагдаагийн аюулгүй байдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “баривчлагдсан этгээдийг өөрийн болон бусдын бие махбодийн аюулгүй байдалд аюул учруулахгүй байх, хоригдох хугацаандаа оргон зайлуулахгүй байх үүднээс олон нийтийн аюулгүй байдлын байгууллага нэгжлэг хийх эрхтэй”



Хариуцагч Вена хотын Цагдаагийн газар давж заалдах гомдолдоо: “Цагдаагийн аюулгүй байдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу нүцгэн биед үзлэг хийхэд ямар нэгэн аюултай нөхцөл байдлыг тогтоох үнэлгээ шаардахгүй тул анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож өгнө үү” гэж давж заалдах гомдол гаргажээ.

Давж заалдах шатны шүүх (Захиргааны дээд шүүх)⁴-ээс: Цагдаагийн аюулгүй байдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1-д заасан **нэгжлэг, үзлэг нь зөвхөн аюулгүй байдлыг хангах зорилготой. Аюултай нөхцөл байдлыг үнэлэхийн тулд эрсдэлийн үнэлгээ хийх ёстой бөгөөд уг үнэлгээ хийгдээгүй. Хариуцагч Вена хотын Цагдаагийн газар гомдол гаргагчийг “цавуу авч явж байж магадгүй” гэж сэжиглэн биед нүцгэн үзлэг хийсэн нь үндэслэлгүй.**

Хүний биеийг нүцгэлж үзлэг хийх ажиллагаа нь Цагдаагийн аюулгүй байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1-д⁵ заасан “бодит байдлын зарчим”-д нийцэх ёстой. Тухайн нөхцөл байдлаас харвал гомдол гаргагч V.B-д супер цавуу байж магадгүй гэж сэжиглэсэн нь хуульд заасан аюултай нөхцөл байдлыг үнэлж, тогтоох зорилгод хамаарахгүй, мөн гомдол гаргагчийн биед супер цавуу байгаа гэх ямар ч бодит нотолгоо байхгүй байсан тул бодит байдлын зарчим алдагдаж хувь хүний эрхэд халдсан байна гэж үзжээ.

Хариуцагчийн гаргасан энэхүү давж заалдах гомдолд Бүгд Найрамдах Австри Улсын Үндсэн хуулийн 133 дугаар зүйлийн 4-т заасан **эрх зүйн суурь асуудлыг хөндсөн асуудал байгаагүй тул анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.** Мөн Холбооны засгийн газрын зүгээс гомдол гаргагчид 1106.40 еврогийн зардлыг нөхөн төлөхийг даалгасан байна.

---000---

⁴ Австри улсын захиргааны хэргийн шүүхийн системийн хувьд давж заалдах шатанд Австри улсын Захиргааны хэргийн дээд шүүх эцсийн шийдвэрийг гаргадаг ба Холбооны хуулиар харьяалуулсан Холбооны захиргааны хэргийн шүүх болон бүс нутгийн 9 захиргааны хэргийн шүүх анхан шатны хүрээнд шийдвэр гаргадаг. The Austrian Judicial System, https://www.justiz.gv.at/file/8ab4ac8322985dd501229d51f74800f7.de.0/cover_und%20text_the%20austrian%20judicial%20system_neu.pdf?forcedownload=true, (Сүүлд үзсэн: 2025.08.10).

⁵ Sicherheitspolizeigesetz (1991), Цагдаагийн аюулгүй байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хэрэв хүний эрхэд халдах шаардлага үүссэн гэж үзвэл энэ нь бодит шалтгаан болон хүрэх үр дүнтэй бодит байдалд нийцэж байгаа үед зөвшөөрөгдөнө”